



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2022/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Увс аймгийн Улаангом сум  
2022 он

Цахим хуудас: [uvs@audit.gov.mn](mailto:uvs@audit.gov.mn)

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: [BatsuuriM@audit.gov.mn](mailto:BatsuuriM@audit.gov.mn)

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: [Bat-Amgalanm@audit.gov.mn](mailto:Bat-Amgalanm@audit.gov.mn)

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит”  
ХХК аудитор: С.Цэрэнминжин

Утас: 99458717

Цахим хаяг: [enhee\\_ja@yahoo.com](mailto:enhee_ja@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	
3. Аудитын тайлан .....	6
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Э.ОДГЭРЭЛ  
ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № 44 - 2022/27/НА - СНА-ТМЗ  
танай - ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200471

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,877,155.00	1,955,800.00
33	АВЛАГА	206,365.00	00.00
335	Бусад авлага	206,365.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	206,365.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,670,790.00	1,955,800.00
354	Хангамжийн материал	1,670,790.00	1,955,800.00
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	60,000.00
35420	Аж ахуйн материал	1,610,790.00	1,895,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,267,497.82	8,686,097.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,267,497.82	8,686,097.74
392	Биет хөрөнгө	9,267,497.82	8,686,097.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,536,177.00	18,084,487.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,557,369.96	-12,204,895.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,164,800.00	6,471,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,876,109.22	-3,665,243.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,144,652.82	10,641,897.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,144,652.82	10,641,897.74
51	Засгийн газрын хувь оролцоо	11,144,652.82	10,641,897.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,091,373.00	6,091,373.00
51101	Өмч: - төрийн	6,091,373.00	6,091,373.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,053,279.82	4,550,524.74
51210	Өмнөх үеийн үр дүн	5,053,279.82	5,053,279.82
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-502,755.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,144,652.82	10,641,897.74

**2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	62,723,177.00	69,406,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,481,177.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,481,177.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,481,177.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,481,177.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,242,000.00	69,406,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,242,000.00	68,591,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,242,000.00	68,591,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	58,042,652.84	69,629,250.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,042,652.84	69,629,250.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,442,244.84	59,357,401.97

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,422,500.00	42,611,617.15
210101	Үндсэн цалин	32,380,100.00	34,086,455.35
210104	Урамшуулал	10,042,400.00	8,525,161.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,737,282.86	5,467,799.22
210201	Тэтгэврийн даатгал	5,276,927.86	3,830,819.96
210202	Тэтгэмжийн даатгал	460,355.00	420,752.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	336,601.13
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	79,965.41
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	799,660.08
2104	Хангамж, бараа материалын зардал	6,780,702.00	3,729,990.00
210401	Бичиг хэрэг	550,010.00	719,890.00
210402	Тээвэр, шатахуун	4,603,592.00	2,685,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	385,300.00	304,700.00
210404	Ном, хэвлэл	1,032,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	209,800.00	20,000.00
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	540,300.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	540,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,300.00	337,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,300.00	193,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,085,459.98	6,670,295.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,801,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,648,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,085,459.98	2,221,195.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,408.00	10,271,848.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	7,479,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,166,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	408.00	2,792,048.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	408.00	2,792,048.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,680,524.16	-222,550.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	280,204.48
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	280,204.48
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-280,204.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,680,524.16	-502,755.08

**2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	58,242,000.00	69,406,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	58,242,000.00	69,406,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	815,000.00

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	815,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,242,000.00	68,591,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,242,000.00	68,591,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	58,242,000.00	69,406,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,242,000.00	69,406,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,641,592.00	59,134,851.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,422,500.00	42,405,252.15
210101	Үндсэн цалин	32,380,100.00	33,880,097.58
210104	Урамшуулал	10,042,400.00	8,525,154.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,726,900.00	5,467,799.22
210201	Тэтгэврийн даатгал	3,898,316.00	3,830,819.96
210202	Тэтгэмжийн даатгал	555,984.00	420,752.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	339,300.00	336,601.13
210204	Ажилгүйдлийн даатгал	84,900.00	79,965.41
210205	Эрүүл мэндийн даатгал	848,400.00	799,660.08
2104	Хангамж, бараа материалын зардал	6,575,892.00	3,725,000.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	708,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,388,592.00	2,685,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	304,700.00
210404	Ном, хэвлэл	1,057,300.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	170,000.00	26,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	0.0
210602	Тавилга	00.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	264,000.00	540,300.00
210702	Дотоод албан томилолт	264,000.00	540,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,300.00	337,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,300.00	193,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	144,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	5,159,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,511,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,648,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,408.00	10,271,848.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	7,479,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	6,313,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	1,166,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	408.00	2,792,048.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	408.00	2,792,048.63
213304	Хөрөнгийн		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,091,373.00	00.00	372,755.66	6,464,128.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,091,373.00	00.00	372,755.66	6,464,128.66
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			4,680,524.16	4,680,524.16
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,091,373.00	00.00	5,053,279.82	11,144,652.82
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,091,373.00	00.00	5,053,279.82	11,144,652.82
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-502,755.08	-502,755.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,091,373.00	00.00	4,550,524.74	10,641,897.74

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	68,591,700.00	65,799,651.37	2,792,048.63	96%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	68,591,700.00	65,799,651.37	2,792,048.63	96%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	61,111,900.00	58,319,851.37	2,792,048.63	95%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	43,922,500.00	42,405,252.15	1,517,247.85	97%
210101	Үндсэн цалин	33,880,100.00	33,880,097.58	2.42	100%
210104	Урамшуулал	10,042,400.00	8,525,154.57	1,517,245.43	85%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,906,900.00	5,467,799.22	439,100.78	93%
210201	Тэтгэврийн даатгал	4,150,100.00	3,830,819.96	319,280.04	92%
210202	Тэтгэмжийн даатгал	439,200.00	420,752.64	18,447.36	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	351,300.00	336,601.13	14,698.87	96%
210204	Ажилгүйдлийн даатгал	87,900.00	79,965.41	7,934.59	91%
210205	Эрүүл мэндийн даатгал	878,400.00	799,660.08	78,739.92	91%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,725,100.00	3,725,000.00	100.00	100%
210401	Бичиг хэрэг	619,800.00	708,900.00	-89,100.00	114%
210402	Тээвэр, шатахуун	2,645,500.00	2,685,400.00	-39,900.00	102%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	321,100.00	304,700.00	16,400.00	95%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	138,700.00	26,000.00	112,700.00	19%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
210602	Тавилга	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	540,300.00	540,300.00	0.00	100%
210702	Дотоод албан томилолт	540,300.00	540,300.00	0.00	100%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	409,400.00	337,400.00	72,000.00	82%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	193,400.00	193,400.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	144,000.00	72,000.00	67%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5107700.00	4344100.00	763,600.00	85%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,274,700.00	3,511,100.00	763,600.00	82%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	833,000.00	833,000.00	0.00	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7479800.00	7479800.00	0.00	100%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,479,800.00	7,479,800.00	0.00	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	6,313,200.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,166,600.00	1,166,600.00	0.00	100%

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	68,591,700.00	68,591,700.00	0.00	100%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	68,591,700.00	68,591,700.00	0.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	68,591,700.00	68,591,700.00	0.00	100%
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	#DIV/0!
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	7	7	0.00	100%
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100%

**2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>				
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2109</b>	<b>раа үйлчилгээний бусад зардал</b>				
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>31</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	815,000.00	815,000.00	<b>0.00</b>	<b>0.00</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Увс Финанс Аудит" ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Увс Финанс Аудит" ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна. Харин Орон нутгийн өмчийн албанаас төсөвт байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 58,042.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,160.8 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 69,629.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,392.5 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг тооцох хувийг 80 хувиар тооцож 1,114.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 502.7 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	206,365.00	00.00	-206,365.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	1,670,790.00	1,955,800.00	285,010.00
Үндсэн хөрөнгө	9,267,497.82	8,686,097.74	-581,400.08
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,144,652.82</b>	<b>10,641,897.74</b>	<b>-502,755.08</b>

**Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Өр төлбөр	0.0	0.0	72,000.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,144,652.82	10,641,897.74	-502,755.08
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,144,652.82</b>	<b>10,641,897.74</b>	<b>-502,755.08</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Хувь хүний орлого албан татварын авлагыг суутган тооцож үлдэгдэлгүй болж авлага буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,955.8 мянган төгрөг болж 285.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан аж ахуйн материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Оны эцэст бараа материалын нэмэгдсэн нь байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулах холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,686.1 мянган төгрөг болж 581.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,641.8 мянган төгрөг болж 502.70 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь авлага, бараа материалын данс байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,683.5 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 11,586.5 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын зардал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна. Өмнөх онтой харьцуулахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал шинээр төлөвлөсөн, албан хаагч нэг удаагийн тэтгэмжийн зардал нэмэгдсэн.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 77,472.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 77,472.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 8,880.7 мянган төгрөгөөр бууруулж 68,591.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс- 2090.7 мянга, хичээл үйлдвэрлэл дадлага хийх- 6790.0 мянган төгрөгийн зардал тус тус төлөвлөсөн зардал хасагдсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 68,591.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 68,591.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 68,591.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 68,591,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 68,591.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 65,799.6 мянган төгрөг буюу 96 хувьтай гүйцэтгэл гарч 2,792. 0 төгрөгийн үлдэгдэл төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 815.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр өгсөн байна.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 815.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Зүүнхангай сумын

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул түүвэрт хамруулж Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгах аар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 116, хугацаа хоцроож 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан төсвийг зарцуулахаас хагас өнчин хүүхдүүдэд бэлэг өгөхөд 180.0 мянга, цагдаагийн кабоны интернэтийн төлбөрт 363.0 мянга, нийт 543.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсныг баримтжуулсан ажлын тайлангүй бензин шатахууны зарцуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг авч ажиллаж 2,792.0 мянган төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 654.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс 70.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 543.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө.

### 4.1 Зөвлөмж

Үүнд:

#### 1. *Зардалтай холбоотой асуудал*

Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийн шийдвэр тодорхой бус, зарцуулсан шатахууны ажлын тайлангүй байна.

##### 1.1. Өгсөн зөвлөмж:

1. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 тоот хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дахь хэсэгт тусгагдсан зардлыг санхүүжүүлэх.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд захиран зарцуулах хөрөнгийн шийдвэрийг тодорхой төсөвтэй гаргах
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан шатахууны ажлын тайлан гаргаж байх.

**4.2 Албан шаардлага**

**2. Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас хагас өнчин хүүхдүүдэд бэлэг өгөхөд 180.0 мянга, цагдаагийн кабоны интернэтийн төлбөрт 363.0 мянга, нийт 543.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Зүүнхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	654.7					2	543.0	1	70.7


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН::

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2022 оны 2-р сарын 17-ний өдөр